

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 09 дүгээр сарын 29 ны өдөр
2022-10-13

№ 2022/154
119/2022 Улаанбаатар хот

Нэг талаас “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж Захиргаа удирдлагын хэлтсийн Сургалт, бүтээмжийн инженер Лхачинсүрэн овогтой Энхжаргал, нөгөө талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж Сургалт судалгааны мэргэжилтэн Н.Пагмаа нар Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2003 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийг үндэслэн энэхүү гэрээг харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн ажилтнуудад цахилгааны аюулгүй ажиллагааны группын эрх олгох сургалтыг өөрийн мэргэжлийн ур чадвартай инженер, техникийн ажилтнуудаар зохион байгуулах, захиалагч нь энэхүү сургалт зохион байгуулахтай холбогдон гарсан төлбөр төлөх зэрэг талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хавсралт №1-д заасан хөтөлбөрийн дагуу, хавсралт №2-д заасан захиалагчийн ажилтнуудад өөрийн сургалтын танхимд /цахим/ сургалтыг зохион байгуулна.

Хоёр. Гэрээний үнэ

- 2.1 Захиалагч нь сургалтын төлбөр болох 1,858,560 /нэг сая найман зуун тавин найман мянга таван зуун жар/-н төгрөгийг гүйцэтгэгчийн Төрийн банк дахь 346 900 248 559 /ЦДҮС/ дансанд шилжүүлнэ. Үнийн дүнд НӨАТ орсон болно.
- 2.2 Сургалтын төлбөрийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам”-ыг үндэслэн гэрээний Хавсралт №3-д тусгасны дагуу тооцсон болно.

Гурав. Хугацаа

- 3.1 Энэхүү гэрээ нь 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл 1 сарын хугацаатай бөгөөд талууд гэрээний үүргээ бүрэн биелүүлж, гэрээ дүгнэж акт үйлсэн байна.

Дөрөв. Талуудын хүлээх үүрэг.

- 4.1 Захиалагчийн эрх, хүлээх үүрэг:
 - 4.1.1 Сургалтад хамрагдах ажилтнуудын нэрсийн жагсаалтыг гүйцэтгэгч талд гаргаж өгнө.
 - 4.1.2 Суралцагсдын сургалтын хугацаанд идэвхи зүтгэлтэй суралцах, хичээлээс хочрох, таслах явдлыг гаргахгүй байх тал дээр анхаарна.

- 4.1.3 Суралцагсад нь цахилгааны мэргэжлээр их дээд сургууль төгссөн, ажлын байрны шаардлага хангасан, дадлага туршлагатай байна.
- 4.1.4 Суралцагсдын шуурхай ажиллагааг найдвартай зохион байгуулж, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг захиалагч тал хариуцна.
- 4.1.5 Захиалагч нь аюулгүй ажиллагаа хариуцагч нарын тушаалыг өөрийн байгууллага дээр гаргаж, хэрэгжүүлнэ.
- 4.1.6 Сургалт эхэлснээс хавсралт №2-д заасан суралцагчдыг солихгүй.
- 4.2 Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг:
- 4.2.1 Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай явуулна.
- 4.2.2 Гүйцэтгэгч нь сургалттай холбоотой ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба сургалтын батламж, мэргэшлийн үнэмлэх олгохгүй.
- 4.2.3 Цахилгааны аюулгүй ажиллагааны шалгалтанд тэнцсэн ажилтнуудад группын үнэмлэх олгоно.
- 4.2.4 Гэрээний төлбөрийг хугацаандаа төлөхийг шаардах.
- 4.2.5 Халдварт хамгааллын дэглэмийг баримтлах.

Тав. Гэрээ цуцлах

- 5.1 Дараах тохиолдолд талууд гэрээг цуцална.
- 5.1.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй.
- 5.1.2 Захиалагч гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол гүйцэтгэгчийн санаачлагаар.
- 5.2 Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг цуцалсан тохиолдолд учирсан шууд болон шууд бус аливаа хохирлыг буруутай тал нөхөн төлнө.

Зургаа. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал

- 6.1 Талуудын аль нэг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 6.2 Дээрхи нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц гүйцэтгээгүй үүргээ нөхөн гүйцэтгэж болно.
- 6.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжээгүй тохиолдолд гэрээний аль нэг тал нөгөө талаасаа алданги, торгууль зэрэг аливаа хохирлыг нөхөн төлөхийг шаардахгүй болно.
- 6.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнийг зөвхөн эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн тогтооно.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1 Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэнэ.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн тохиролцож шийдвэрлэнэ.

Найм. Бусад нөхцөл

- 8.1 Энэхүү гэрээг монгол хэл дээр тус бүр 4 хувь үйлдэн, Захиалагч 2, Гүйцэтгэгч 2 хувийг тус тус хадгална.
- 8.2 Талууд гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.3 Талууд энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд албан бичиг үйлдэж эрх бүхий албан тушаалтнууд гэрээний нэмэлт өөрчлөлтөнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

- 8.4 Захиалагчийн гаргасан жагсаалтад тусгагдсан суралцагч сурахгүй шинэ суралцагч суралцах бол захиалагч талаас албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд өөрчилж болох ба хичээл эхэлснээс ажлын 1 хоногийн дараа суралцагчийг солихгүй.
- 8.5 Сургалтыг зөвхөн сургалт эхлэхээс өмнө хойшлуулах боломжтой бөгөөд сургалт эхэлсэн тохиолдолд хойшлуулах боломжгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженерийн албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч


Б.Дашдаваа


Ерөнхий нягтлан бодогч


Э.Түмэнжаргал

ЗУХ-ийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн


Г.Үрэлмаа

ЗУХ-ийн сургалт, бүтээмжийн инженер


Л.Энхжаргал


Хаяг: "Цахилгаан Дамжуулах Үндэсний
Сүлжээ"ТӨХК-ийн Хан-Уул дүүрэг, 3-
дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45,
Утас:70042939, 99191300
Факс:976-70043287

ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:


Ерөнхий инженер


Э.Мөнхжаргал

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга


Б.Ган-Очир

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
бөгөөд Ерөнхий нягтлан бодогч


Ө.Удвал

Сургалт, судалгааны мэргэжилтэн


Н.Пагмаа

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
8-р хороо ус-15-1-1 тоот "Амгалан
Дулааны Станц" ТӨХК-ийн захиргааны
байр
Утас: 77111252; 98071123

**"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН АШИГЛАЛТЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ЦАХИЛГААНЫ
АА-НЫ ГРУШЫН ЭРХ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2022.09.29

л/д	Хичээлийн сэдэв	Багшийн нэр	Цаг	Хичээл заах өдөр, цаг, минут	Сургалт явагдах газар
1	Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, ХАБЭА-н тухай хууль	Б.Багчулуун /ХМХ-н ХАБЭАИ/ Б.Лут-Эрдэнэ /РХАХТХ-н Өндөр хүчдэлийн туршилтын инженер/	2	2022-10-03 08:50-10:20	Сургалтыг цахимаар зохион байгуулна.
2	"Өндөр хүчдэлийн хэмжилт, туршилт"-ын тухай, гүүний норм стандарт, нэр томъёо, тавигдах шаардлага	А.Эрдэнэбилэг /Зөвлөх инженер/	2	2022-10-04 08:50-10:20	
3	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм	З.Багзориг /РХАХТХ-н ахлах бөгөөд РХА-н инженер/	2	2022-10-04 14:30-16:10	
5	Дамжуулах сүлжээнд ашиглагдаж буй Реле хамгаалалт, автоматикийн байгууламж гэдгээрийн онцлог, ялгаатай талууд	Ч.Баг-Эрдэнэ /ЛШЗХ-н диспетчер инженер/	4	2022-10-05 08:50-12:00	
6	Нэгдсэн сүлжээний схем, шуурхай ажиллагаа, сэлгэн залгалт хийх онолын ухагдахуунууд	М.Сэржхорол /ЛШЗХ-н диспетчер инженер/	4	2022-10-06 08:50-12:00	
7	Шуурхай ажиллагааны хүмүүсийн харьцааны заавар, Ашиглалтын ажилтнуудын үүрэг хариуцлага, ээлжийн хугацаанд хийж гүйцэтгэх ажлууд	ЦДҮС ТӨХК-н МППК	8	2022-10-07 08:50-16:10	
8	Мэргэжлийн шалгалтын комисст шалгалт өгөх				

ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАСАН:
"ЦДҮС" ТӨХК-ийн ерөнхий инженер

Б.Дашдаваа

ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН:

"ЦДҮС" ТӨХК-ийн ЗУХ-ийн сургалт бүтээмжийн инженер
"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Ерөнхий инженер

Л.Энхжаргал
Э.Мөнхжаргал

**СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС
МЭДЭЭЛЭЛ**

2022.09.29

д/д	Овог нэр	Албан тушаал	Төгссөн сургууль, мэргэжил	Төгссөн он	Ажил эрхлэлт
1	Э.Мөнхжаргал	Ерөнхий инженер	ШУТИС-ЭХС- Дулааны инженер, Программ хангамжийн инженер	2009	2005 он Клеар компанид инженер, 2012 -2021 онд ЖМДМ ХХК-ийн Захирал
2	Т.Ангараг	Техник хяналтын инженер	Дулааны цахилгаан станц	2012	М-СИ-ЭС Интернэйшнл ХХК, Амгалан дулааны станц-Ашиглалтын өмнөх захиргаа төслийн нэгж
3	Л.Цэцэгсүрэн	ХАБЭА инженер	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт		Амгалан дулааны станц ТӨХК
4	Ц.Мандахсайхан	Ээлжийн инженер	Аж үйлдвэрийн дулаан хангамж	2010	Юнайгэд Пауэр ХХК, М-СИ-ЭС Интернэйшнл ХХК, Амгалан дулааны станц-Ашиглалтын өмнөх захиргаа төслийн нэгж
5	С.Түвшинбат	Ээлжийн инженер	Дулааны цахилгаан станц	2013	Хасу Мегаватт ХХК
6	Б.Ган-Эрдэнэ	Ээлжийн инженер	Дулааны инженер	2018	УБДС ТӨХК, ДЦС-2 ТӨХК
7	Т.Цэнгэл	Ээлжийн инженер	Хийн хангамж, нефтийн инженер, Дулааны цахилгаан станц, Зуухны машинист /IV зэрэг/	2011, 2018	Юнигаз ХХК, Амгалан дулааны станц-Ашиглалтын өмнөх захиргаа төслийн нэгж
8	Ж.Ариунжаргал	Нэгдсэн цехийн дарга	Дулааны ашиглалтын инженер	2003	Багануурын ДС ТӨХК, БЗӨБЦТС ТӨХК, Тэдмэнт ХХК
9	А.Нямцэрэн	Цахилгааны инженер	Цахилгааны инженер	2010	Юнайгэд Пауэр ХХК, М-СИ-ЭС Интернэйшнл ХХК
10	Л.Пүрэврагчаа	Цахилгаанчин	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	2009	Юнайгэд Пауэр ХХК, М-СИ-ЭС Интернэйшнл ХХК, Амгалан дулааны станц-Ашиглалтын өмнөх захиргаа төслийн нэгж

11	Т.Оюун-Эрдэнэ	Цахилгаанчин	Цахилгааны инженер	2015	Амгалан дулааны станц ТӨХК
12	Н.Очирхуяг	Цахилгаанчин	Цахилгаан хангамжийн инженер /ЭХСҮЦ-Хуваарилах байгууламж дэд станц E2 мэргэшил/	2016	Саянтүрүү ХХК
13	М.Содномдаржаа	Цахилгаанчин	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	2015	Амгалан дулааны станц ТӨХК
14	П.Энх-Од	Цахилгаанчин	Цахилгааны мэргэжлээр Хуваарилах байгууламж, дэд станцын монтёр, Цахилгааны инженер	2020	Амгалан дулааны станц ТӨХК
15	Б.Амаржаргал	Цахилгаанчин	Цахилгаанчин /Ш/	2013	Дотоодын цэргийн 05-р анги
16	Г.Алтанабагана	Цахилгаанчин	Цахилгааны мэргэжлээр хуваарилах байгууламж, дэд станц монтёр E1	2017	ЗХ-ний 032р анги
17	Б.Ууганбат	Цахилгаанчин	Цахилгаан хөдөлгүүрийн хүчний ба удирдлагын хэлхээ, гэрэлтүүлэг, Олон улсын эдийн засгийн харилцаа	2017	Амгалан дулааны станц ТӨХК
18	Н.Энхбаяр	Цахилгаанчин	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, Авто машины механикч, Сантехникч, Тоног төхөөрөмжийн засварчин, Эрсдэлийн менежмент, мэргэжлийн хөргөгч хөлдөөгч, кондешн засварчин, ХАБЭА, Дизель экскаваторын операторчин	2012	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ, Анибус ХХК
19	Д.Мөнхдөл	Реле хамгаалалт, автоматикийн инженер	Цахилгаан холбоо, холбооны инженер, ЦСА	2012	ХААН банк, Скайтел ХХК, Амгалан дулааны станц-Ашиглалтын өмнөх захиргаа төслийн нэгж
20	А.Бямбадорж	Реле хамгаалалт, автоматикийн монтёр	Цахилгаан хангамж	2019	Мон цахим ХХК, Буман Эксплорейшн ХХК, Мон ирээдүй ХХК

21	Э.Одбаяр	Реле хамгаалалт, автоматикийн монтёр	ЦСА	2019	Амгалан дулааны станц ТӨХК
----	----------	---	-----	------	-------------------------------

ТАНИЛЦСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Э.МӨНХЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН



Н.ПАГМАА

**БАШГИЙН ХӨЛС БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ГРУППЫН ҮНЭМЛЭХ ОЛГОХ,
ЭРХ СУНГАХ ЗАРДЛЫН ТООЦООЛЛЫН ХҮСНЭГТ**

2022.09.29

А. СУРГАЛТЫН ТӨЛБӨР				
д/д	Зардлын нэр	Цаг	Цагийн төлбөр	Нийт төлбөр
1	Танхимын сургалтын төлбөр	24	20,000	480,000
<i>Сургалтын төлбөрийн нийт дүн</i>				480,000
Б. БАГШИЙН ХӨЛСӨД НОГДОХ НДШ-ИЙН ЗАРДАЛ				
1	Багшид олгох хөлс	24	20,000	480,000
<i>Нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагдах зардал /14,5 хувь/</i>				69,600
В. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ГРУПП ОЛГОХ БОЛОН БУСАД ТӨЛБӨР				
д/д	Зардлын нэр	Тоо	Нэгжийн үнэ	Нийт төлбөр
1	АА-ны групп олгох, сунгах ажилтны тоо	21	20,000	420,000
2	Анги танхим, техник хэрэгсэл ашигласны төлбөр	24	30,000	720,000
<i>АА-ны групп олгох болон бусад төлбөрийн дүн</i>				1,140,000
НИЙТ ЗАРДАЛ				1,689,600
<i>НӨАТ-10%</i>				168,960
Гэрээний нийт дүн				1,858,560

ХЯНАСАН:

ЦДҮС ТӨХК-ийн Ерөнхий ня-бо



Э.ТҮМЭНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЦДҮС ТӨХК-ийн ЗУХ-ийн Сургалт, бүтээмжийн инженер



Л.ЭНХЖАРГАЛ